

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.

Б.Одбаатар

ДХИС-ийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага,
стратегийн профессорын багийн профессор, хууль зүйн
доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа

Товч агуулга. Энэхүү нийтлэлээр цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамтын ажиллагааны түүхэн уламжлал, түүний эрх зүйн зохицуулалт, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд үнэлэлт өгөхийг зорилоо.

Түлхүүр үгс. цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хамтын ажиллагаа, гэмт хэрэгтэй тэмцэх, мэдээллийн ил тод байдал.

Оршил. Цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамтын ажиллагааны түүхэн хөгжилд үнэлэлт дүгнэлт өгөх хэмжээний материал 1991 оноос өмнө харьцангуй бага байгаа нь нэг талаас нийгмийн хөгжлийн социалист тогтолцоо, нэг намын үзэл суртлын бодлого хэрэгжиж хэвлэл мэдээллийн хэрэгслийн харьцангуй хаалттай систем оршиж байсантай холбож болох боловч нөгөө талаас 1990-ээд он хүртэл аль нэгэн байгууллагын, тэр дундаа цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээлэхээс илүүтэй нийгмийн бүтээн байгуулалт, хөгжил дэвшлийг харуулсан нэгэн хэвийн мэдээлэлийг олон нийтэд түгээж байсантай холбоотой гэж дүгнэж болох юм.

1991 онд Монголын цагдаагийн байгууллагын 70 жилийн

ойг угтсан ажлын хүрээнд ЦЕГ-ын тэргүүн дэд даргаар удирдуулсан тусгай комисс цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах тусгай хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллаж цагдаагийн байгууллага, алба хаагчийн амьдрал, хөдөлмөрийг харуулсан түүхэн замналын цомог, “Нүгэл буяны дэнс”, “Түүхээ тольдоход”, “Чамайгаа хайрлаж чамаараа түшүүлнэ”, “Бурхан багшаа худалдсан нь”, “Талийгаачаас асуу”, “Нууц түймэр” зэрэг ном гаргаж олны хүртээл болгож, “Монголын цагдаа-70” телевизийн баримтат кино бүтээжээ. Түүнчлэн цагдаагийн байгууллага, алба хаагчийн ажил, үйлсийн талаар радио, телевизээр 1000 гаруй нэвтрүүлэг¹, сонин сэтгүүлд 200 гаруй материал, “Нүгэл буян” сонины 23 дугаарыг гаргасан нь олон нийтэд

¹ Гавъяат хуульч С.Дамдин, Р.Доржпалам, амь эрсэдсэн Гомбосүрэн. Ц, Бадамханд.Ц, зэрэг 20 гаруй алба

хаагчийн амьдрал, хөдөлмөрийг радио, телевизээр нэвтрүүлж байжээ.

цагдаагийн албаны ажил, мэргэжлийн онцлогыг таниулахад ихээхэн ач холбогдолтой болсон гэж дүгнэж болно¹.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа түүний дотор гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, уг ажилд олон нийтийг татан оролцуулах, олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоог гэмт хэрэгтэй тэмцэх ажилд идэвхитэй оролцуулах үүднээс 1992 онд хэвлэлийн бага хурлыг хоёр удаа зохион байгуулж, сонин хэвлэлд 720 гаруй материал, радио телевизээр 920 орчим нэвтрүүлэг явуулж, “Нүгэл буян” сонины 18 дугаар, “Цагдаа” сэтгүүлийг улирал бүр гаргаж, цагдаагийн музейн санд 300 гаруй үзмэр, үзүүлэнг бүрдүүлэн ажиллахын зэрэгцээ гэмт явдлын хор уршгыг олон нийтэд ойлгуулан таниулах, сэрэмжлүүлэх зорилгоор “Амилсан чөтгөр” уран сайхны киног бүтээж үзэгчдэд хүргэсэн нь тухайн үедээ олны сэтгэлд хүрсэн бүтээл болсон гэж үнэлэгдсэн байна.

1996 онд “Цагдаагийн дуудлага-102” телевизийн тогтмол нэвтрүүлгийг бэлтгэж 7 хоногт 1, сард 4 удаа, “Цагдаагийн түүх” ая дууны мэндчилгээ, “Ахмадын дурсамж” сэдэвт телевизийн бие даасан нэвтрүүлгийг 5 удаа бэлтгэж олон нийтэд хүргэсэн байна. Түүнчлэн цагдаагийн байгууллагын 75 жилийн ойд зориулсан “Түмний түшиг” баримтат, нийтлэлийн телевизийн киног кино үйлдвэрийн болон төв телевизийн уран бүтээлчидтэй хамтран бэлтгэж олон нийтэд цагдаагийн албаны үйл ажиллагааг

сурталчлан ажиллажээ. Төрийн төв хэвлэл “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонинд цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой нийтлэгдсэн 26 нийтлэлийг шалгаж, “Ардын эрх” сонинд 4, “Засгийн газрын мэдээ” сонинд 1, Монгол телевизэд хоёр удаа тус тус тайлбар явуулсан байна.

“Нүгэл буян” сонины нийтлэлийн бодлого шинэчлэгдэн тухайн үед үйлдэгдэж олны жигшил дургүйцлийг хүргэсэн, олон нийтийг айлган цочоосон, тэдний анхаарлыг илтэд татах дуулиант, онц ноцтой гэмт хэргийн талаар нийтлэх болсон нь сонины борлуулалт, эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэж захиалгын тоо 30 орчим мянга, үүргийн худалдаагаар 10 мянган ширхэг зарагдах болсон байна².

Эндээс дүгнэхэд 1996 оноос цагдаагийн байгууллага, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хамтын ажиллагаа олон талт хэлбэрээр өргөжих эхлэл тавигдсан гэж дүгнэж болохоор байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цагдаагийн алба хаагчийн албаны болон мэргэжлийн сургалтад хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглах, олон нийтэд сурталчлах зорилгоор ЦЕГ-ын даргын 1997 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 77 дугаар тушаалаар тус газрын Тамгын хэлтэст “Хэвлэл мэдээллийн хэсэг”-ийг анх удаа байгуулсан байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл

¹ ЦЕГ-ын Төв архив. ЦЕГ-ын 1991 оны ажлын тайлан. хөмрөг 14, данс 1.

² ЦЕГ-ын Төв архив. ЦЕГ-ын 1996 оны ажлын тайлан.

мэдээллийн хэрэгслээр сурталчлах, алба хаагчдын хууль эрх, ёс зүй, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалт арга зүй, мэдээлэл сурталчилгааны ажлыг хариуцан хийх “Мэдээлэл сурталчилгааны хэсэг”-ийг байгуулан түүний ажиллах журам, чиглэлийг ЦЕГ-ын даргын 1999 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 185 дугаар тушаалаар, түүнчлэн “Цагдаагийн байгууллагаас хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээ, материал өгөх, тэдэнтэй хамтран ажиллах, сурталчилгааны ажлыг сайжруулах заавар журам”-ыг боловсруулан ЦЕГ-ын даргын 1999 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 103, мөн оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 799 дүгээр тушаалаар тус тус батлан мөрдөж эхэлсэн байна.

Архивын баримтаас үзэхэд энэ үед “Цагдаагийн теле студи”-ийг байгуулж ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын даргаар студийн үйл ажиллагаанд мөрдөх журмыг батлан ажиллуулж эхэлсэн бөгөөд дараах үндсэн зорилго, чиглэлтэйгээр цагдаагийн байгууллагыг олон нийтэд сурталчлан ажиллаж байжээ. Үүнд:

- Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн ухамсар, цагдаагийн албаны болон алба хаагчийн мэдлэг, чадвар, дадлагыг дээшлүүлэх, бие бялдрын бэлтгэлийг хангах чиглэлээр сургалтын кино бичлэг хийх;

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах болон цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах мэдээ, материал, нэвтрүүлэг бэлтгэж телевизийн эфирт хүргэх;

- Цаг үеийн арга хэмжээ, зарим шаардлагатай болон тэмдэглэлт үйл явдлын талаар баримтжуулан архивлах;

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд оролцон бэхжүүлэх, баримтжуулах ажлыг гүйцэтгэх зэрэг хэлбэртэй байжээ.

Энэ үед цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах талаар томоохон ажлыг төлөвлөн, зохион байгуулж ажиллаж байсны тод жишээ цагдаагийн байгууллагаас хэвлэл мэдээллийн албанд болон ард иргэдэд мэдээлэл хүргэх, хамтран ажиллах үндсэн чиглэлийг тодорхойлсон явдал бөгөөд үндсэндээ дараах чиглэлээр хамтран ажиллаж байжээ гэж дүгнэж болохоор байна.

- Цагдаагийн байгууллагын үүрэг зорилт, үйл ажиллагаа, хийж хэрэгжүүлж буй ажлын тухай мэдээ, мэдээллийг Монголын радио, телевиз, сонин хэвлэлээр бүрэн чөлөөтэй байнга нийтэлж, нэвтрүүлэх;

- Гэмт хэрэгтэй холбогдол бүхий мэдээ, мэдээллийг хэдийд, ямар хэмжээнд, хаана өгөхийг цаг тухайд нь шийдвэрлэж, ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн төлөөлөгчөөр дамжуулан албан ёсоор өгөх;

- Шаардлагатай гэж үзвэл радио, телевиз, сонины редакцитай албан ёсны гэрээ байгуулан тогтмол харилцаатай ажиллах ба эдгээр олон нийтийн мэдээллийн албанд мэдээ, мэдээллийг илүү хүртээмжтэй өгөх (тухайн үед гэрээтэй хамтран ажиллаж байсан Монголын радио, Үндэсний телевиз);

- Зарим томоохон арга хэмжээнд сэтгүүлч, сурвалжлагч нарыг урьж оролцуулах;

- Цагдаагийн байгууллагатай байнга хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн албадын төлөөлөгчдийг урьж нийтлэг болон тодорхой чиглэлийн асуудлаар мэдээлэл өгч, тэдний сонирхсон асуултанд хариулт өгч байх зорилго бүхий уулзалт, ярилцлагыг өргөн хэмжээгээр жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах;

- Телевиз, радио, сонины редакцийн газраас цагдаа, хуулийн чиглэлийн мэдээ, мэдээлэл хариуцан ажилладаг сэтгүүлч, сурвалжлагч нарт болон цагдаагийн байгууллагын харьяа албадын хэвлэл мэдээлэл, соён гэгээрүүлэх ажил хариуцдаг алба хаагчдыг хамруулсан семинар, сургалт зохион явуулж, тэднийг мэргэшүүлэх бодлого баримтлах;

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой иргэд, олон нийтээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хэвлэлийн мэдээ материалд байнга анхаарч, мөрөөр нь ажил зохиож, түргэн шуурхай, зөв шийдвэрлэж тухай бүр олон нийтэд үнэн зөв мэдээллийг хүргэх;

- Мэдээ, мэдээлэл хүлээн авах тусгай дугаар бүхий утсыг байнга ажиллуулж шуурхай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж ажиллах;

- Тэргүүний алба хаагчийн ажлын амжилт, арга туршлагыг сурталчилж, алдаршуулах ажлыг тогтмол явуулах;

- Мэдээлэл, сурталчилгаанд шаардлагатай төсөв, хөрөнгийг жилийн төсөвт суулгуулж, шинэ хэлбэрийн сурталчилгаа, видео бичлэгт зарцуулах;

- Цагдаагийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, санамж, сэрэмжлүүлэг өгөх чиглэлээр видео, кино бэлтгэж хүргэх зэрэг олон талт чиглэлээр ажиллаж байсан байна.

Харин дараах чиглэлээр олон нийтэд мэдээ, мэдээлэл тараахыг хатуу хориглож байжээ. Үүнд:

- Гүйцэтгэх ажил, эрэн сурвалжлах ажиллагааны арга барилтай холбоотой баримт мэдээлэл;

- Эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны явцад олж авсан хохирогч, сэжигтний хувийн нууцтай холбоотой мэдээ, мэдээлэл;

- Гэмт хэргийг илрүүлэхэд ашигласан арга, ажиллагаа;

- Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагааны нууцлалтай холбоотой мэдээ, мэдээлэл;

- Эзэн холбогдогч, учир шалтгаан нь тогтоогдоогүй байгаа гэмт хэргийн тухай мэдээлэл;

- Улс төрийн шинж, утга агуулга бүхий мэдээллийг олон нийтэд хүргэхийг хориглох чиглэл баримтлан ажиллаж байсан байна.

Архивын баримтаас үзэхэд цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамтын ажиллагаа 2009 оноос өргөжиж өргөн цар хүрээтэй, байнгын үйл ажиллагааг тогтмол явуулж ирсэн нь харагдаж байна. Тухайлбал:

1. ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн төв гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монголын үндэсний радиогийн “Монгол цагдаа” нэвтрүүлгээр цагдаагийн байгууллагын алба, нэгж, алба хаагчийн үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр давтсан цагаар 88 удаа,

“Буянт мал” нэвтрүүлгээр мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр давтсан цагаар 22 удаа, “Хурд” мэдээллийн агентлагийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давтсан цагаар 36 удаа, Монголын үндэсний телевизээр долоо бүрийн лхагва гаригт 15 минутын хугацаатайгаар “Цагдаагийн мэдээлэл” 49 удаагийн нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэж, “MYONT”, “TV-5”, “TV-8”, “UBS”, “TV9”, “Eagle”, “C-1”, “TM”, “STV”, “Айст”, “Монгол”, “BTV” телевизээр нийт 377 удаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл хүргэсэн;

2. Мөн өдөр тутмын тогтмол хэвлэл болох “Өнөөдөр, “Өнөөдрийн монгол”, “Өдрийн сонин”, “Нийгмийн толь”, “Зууны мэдээ”, “Үнэн”, “Өглөөний сонин”, “Монголын мэдээ”, “Ардын эрх”, “Сэрүүлэг”, “Хүмүүс”, “Үндэсний шуудан” сонинд нийт 763 мэдээ, мэдээлэл, нийтлэл, ярилцлага өгсөн;

3. ЗЦГ-ын “Авто радио 96.3FM”-тэй хамтран лхагва гариг бүр 12.30-13.30 цагийн хооронд “Хэвлэл мэдээллийн төвөөс ярьж байна” нэвтрүүлгийг 37 удаа бэлтгэн явуулсан;

4. “MYONT”-ийн “Өглөө”, “Гэрэлтэй цонх” хөтөлбөрөөр цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор цагдаагийн 10 алба хаагч хөтөлбөрт оролцсон;

5. “Эх орон” телевизтэй хамтран ажиллах гэрээний дагуу 7 хоногийн

мягмар гараг бүр “Эх орны цагдаа” 30 минутын нэвтрүүлэг бэлтгэн 2010 оноос эхлэн гаргахаар гэрээ байгуулсан;

6. “ТВ-5” телевизийн “Зохиогчийн хөтөлбөр” нэвтрүүлэгт “Гэмт хэрэг” сэдэвт 5 минутын булан нээж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7 удаа сэрэмжлүүлэг, мэдээ явуулсан¹.

Энэ байдлаас дүгнэхэд 2009 оноос цагдаагийн байгууллагатай байнгын харилцаатай үйл ажиллагаа явуулдаг телевиз, радиогийн тоо нэмэгдэж олон нийтэд мэдээллийг цаг тухайд нь хүртээмжтэй хүргэх боломж улам бүр өргөн болсон нь харагдаж байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах харилцааг зохицуулах зорилгоор ЦЕГ-ын даргын 2012 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 611 дүгээр тушаалаар “Байгууллагын ил тод байдлыг хангах, сурталчлах журам”-ыг батлан гаргасан бөгөөд уг журмыг ЦЕГ-ын даргын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 911 дүгээр тушаалаар “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах журам” болгож өөрчлөн үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллаж байжээ.

Журамд зааснаар хууль тогтоомжийн дагуу нууцад хамруулснаас бусад бүх мэдээлэл иргэд, олон нийтэд нээлттэй, мэдээллээр хангах үйл ажиллагаа хүндрэл чирэгдэлгүй, шуурхай байж, мэдээллийн ил тод байдлыг цахим болон хэвлэмэл хуудас, мэдээллийн самбар ашиглах, алба хаагч

¹ Цагдаагийн ерөнхий газар. Хэвлэл мэдээллийн төв. 2009 оны үйл ажиллагааны тайлан.

мэдээлэл өгөх хэлбэрээр ханган байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байхыг зохицуулсан байна.

Түүнчлэн бүх шатны цагдаагийн байгууллагын дарга байгууллагынхаа мэдээллийн ил тод байдлыг хангах, үйл ажиллагааг сурталчлах ажилд биечлэн хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон бөгөөд цагдаагийн байгууллагын цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл дамжуулахдаа түүнд сөрдөгдөж байгаа этгээд, яллагдагч, зөрчил гаргагчийн гэм буруутай эсэх талаар болон гэрч, хохирогчийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг түгээхийг хориглосон байна.

Цагдаагийн байгууллагын ил тод байдлыг хангах, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Гэр бүлийн радио FM – 104.5”-тай хамтран “Иргэн таны төлөө” нэвтрүүлгийг шинээр нээж 2013 оны 2 дугаар сарын 4-нөөс эхлэн олон нийтэд хүргэсэн байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах харилцааг зохицуулах зорилгоор ЦЕГ-ын даргын 2017 оны 12 сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах журам”-ыг батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллаж байна. Журамд зааснаар иргэн, хуулийн этгээдэд амаар болон цахим хэлбэрээр үнэ төлбөргүй өгөх ба цагдаагийн төв байгууллагын Хэвлэл, мэдээлэл хариуцсан нэгж нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар

хангаж, хяналт тавин ажиллана. Энэ бүхнээс дүгнэхэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг, зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг бүхий л хэлбэрээр олон нийтэд хүргэх үйл ажиллагааг тодорхой стандарт, журамд оруулан ажиллах болсон нь харагдаж байна.

Мөн төв, орон нутгийн газар, хэлтсүүд тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цагдаагийн алба хаагчийг алдаршуулах болон хэвлэлийн шүүмжлэлийн мөрөөр тодорхой ажил зохиож байгаа нь цагдаагийн байгууллагын нэр хүнд дээшлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна гэж дүгнэж болно.

Эх сурвалжийн жагсаалт

1. Олон нийтийн радио телевизийн тухай хууль.
2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай Монгол Улсын хууль.
3. Цагдаагийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга).
4. А.Думбарай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжил. УБ. 2000.
5. Ж.Батбаатар. Суурь сэтгүүл зүй. – УБ., 2010. 165 хуудас.
6. Монголын нээлттэй нийгэм, Соросын сан. Монгол Улс шилжилтийн үед: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн шинжилгээ. – УБ., 2003. 70 хуудас.

7. Цагдаагийн ерөнхий газар. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам: албан хэрэгцээнд. – УБ. 2023.

8. Ш.Үнэнтөгс. Монголын хэвлэл мэдээлэл. – УБ., 2002. 161 хуудас.

9. С.Баасанжав. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил

тод байдлыг хангах арга зам. магистрын судалгааны ажил. – УБ., 2015. 65 хуудас.

10.Цагдаагийн ерөнхий газар. Хэвлэл мэдээллийн төвийн үйл ажиллагааны тайлан.

11.Цагдаагийн ерөнхий газрын архивын баримтууд.